# БҮРТГЭЛИЙН КАРТ

| Хаанаас, хэнээс: Улаанбаатар, ИНЕГ, Л.Бямбасүрэн | | | | Хэнд: Мөнхжаргал.П | |
|---|---|---|---|---|---|
| Бичгийн огноо: 2021.01.08 | Дугаар: А/02 | Бүртгэл №: 62 | Хяналт №: 0 | Хуудас: 11 | Төрөл: Тушаал |
| Товч утга: Ажлын хэсэг байгуулах тухай | | | | | |
| Удирдлагын заалт: | | | | | |
| Шилжүүлсэн газар, нэгж: Удирдлага | | | Шилжүүлсэн огноо: 2021.01.12 | | |
| Хэнд шилжүүлсэн: Мөнхжаргал.П | | | Хариу өгөх огноо: | | |

Бүртгэсэн: Нямцэрэн.С    Огноо: 2021.01.12

Гарын үсэг: . . . . . . . . . . . . . .

МИТ.

# ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 08 өдөр Дугаар А/02 Улаанбаатар хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, Инновацийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны "Цахим болон тоон гарын үсэгт шилжүүлэх тухай" А/160 дугаар тушаал, Иргэний нисэхийн ерөнхий газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 4.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын өгөгдлийн нэгдсэн дижитал санг бий болгож төрийн цахим сүлжээнд холбох, дижитал шилжилтийн хүрээнд ашиглагдах системийн бэлэн байдал, найдвартай ажиллагааг хангах, мэдээллийн аюулгүй байдлын ISO27001 стандартын дагуу цахим халдлагаас урьдчилан сэргийлэх, хамгаалах системийг хэрэгжүүлэх, тоон гарын үсэг нэвтрүүлэх зорилгоор "Дижитал шилжилт хийх" ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Мэдээллийн системийн нэгдсэн менежмент, аюулгүй байдлыг хангах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар, Өгөгдлийн нэгдсэн сан бүрдүүлэх дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар, Тоон гарын үсэг нэвтрүүлэх дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дөрөвдүгээр хавсралтаар, Нэгдсэн дотоод портал бий болгох дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тавдугаар хавсралтаар, Төрийн цахим платформд нэгдэх дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг зургаадугаар хавсралтаар, Нийтийн үйлчилгээний дата төв байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг долоодугаар хавсралтаар, Ажлын хэсгүүдийн ажиллах удирдамжийг наймдугаар хавсралтаар тус тус батлалсугай.

2. Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг төсвийн дагуу гарган зарцуулахыг Иргэний нисэхийн үндэсний төв /П.Мөнхжаргал/-д зөвшөөрсүгэй.

3. Ажлын хэсгүүдийн нэгдсэн төлөвлөгөөг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үр дүнг тухай бүрд нь удирдлагад танилцуулахыг "Дижитал шилжилт хийх" ажлын хэсэг /Ё.Эрдэнэбат/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга /Б.Алтанцом/-д үүрэг болгосугай.

Ё. Эрдэнэбат
Холбогдох албад хавсрах

ДАРГА Л.БЯМБАСҮРЭН

П. М I/12

Алтанцоож
Хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах! 12/I

17120 0013

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2021 оны ..01.. дүгээр сарын ..08..-ны өдрийн
А/02.... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# “ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ ХИЙХ” АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

| | |
|---|---|
| Ё.Эрдэнэбат | Иргэний нисэхийн үндэсний төвийн дэд дарга |

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

| | |
|---|---|
| Ч.Агиймаа | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны дарга |

Гишүүд:

| | |
|---|---|
| Г.Амарцэцэг | Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны аюулгүй ажиллагаа дотоод хяналт хариуцсан менежер |
| С.Нацагдорж | Иргэний нисэхийн үндэсний төвийн Нисэх буудлуудын үйлчилгээний газрын дарга |
| Э.Төрбаяр | Иргэний нисэхийн үндэсний төвийн Агаарын навигацийн үйлчилгээний газрын дарга |
| Б.Батхишиг | Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын дарга |
| У.Өнөрцэцэг | Иргэний нисэхийн үндэсний төвийн Хууль, эрх зүй, хамтын ажиллагааны газрын дарга |
| Ц.Ган-Эрдэнэ | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны менежер |
| Б.Нямбаяр | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны ахлах мэргэжилтэн |
| У.Баярбат | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны мэдээллийн аюулгүй байдлын инженер |

Бүртгэлийн ажилтан:

| | |
|---|---|
| Б.Өлзийцэцэг | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны эдийн засгийн судалгаа, хөгжүүлэлтийн мэргэжилтэн |

------ o0o -----

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2021 оны .01.. дүгээр сарын .08..-ны өдрийн
А/02... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**Мэдээллийн системийн нэгдсэн менежмент,
аюулгүй байдлыг хангах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

Ажлын хэсгийн дарга:

| | |
|---|---|
| Ч.Агиймаа | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны дарга |

Гишүүд:

| | |
|---|---|
| Г.Энхтүвшин | Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны Тоон мэдээллийн хэсгийн системийн инженер |
| Б.Пүрэвзул | “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын Теле мэдээлэл, холбооны албаны дарга |
| Г.Нандин-Эрдэнэ | Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Өгөгдлийн холбооны тасгийн ахлагч инженер |
| Э.Батболд | Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны Захиргаа, хүний нөөцийн хэсгийн мэдээлэл технологийн мэргэжилтэн |
| У.Баярбат | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны Мэдээллийн аюулгүй байдлын инженер |
| Б.Буянхүү | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны инновацийн хөгжлийн мэргэжилтэн |

----- о0о ------

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
А/02 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**Өгөгдлийн нэгдсэн сан бүрдүүлэх дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

Ажлын хэсгийн дарга:

| | |
|---|---|
| Ц.Ган-Эрдэнэ | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны менежер |

Гишүүд:

| | |
|---|---|
| Ц.Солонго | Агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын Эдийн засгийн зохицуулалтын тасгийн агаарын тээврийн мэргэжилтэн |
| А.Ванданмагсар | Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны Аюулгүй ажиллагаа, чанар хангалтын хэсгийн дарга |
| Б.Шинэбаатар | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны программ хангамжийн инженер |
| Б.Батбилэг | Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны Захиргаа, хүний нөөцийн хэсгийн мэдээллийн технологийн мэргэжилтэн |
| Э.Базаррагчаа | Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Өгөгдлийн холбооны тасгийн өгөгдлийн холбооны инженер |

------ o0o ------

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн
А/02 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

**Тоон гарын үсэг нэвтрүүлэх дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

Ажлын хэсгийн дарга:

| | |
|---|---|
| Б.Нямбаяр | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны ахлах мэргэжилтэн |

Гишүүд:

| | |
|---|---|
| Ч.Мөнхзул | Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын Дүрэм боловсруулалтын тасгийн мэргэжилтэн |
| З.Туяа | Иргэний нисэхийн үндэсний төвийн Хууль, эрх зүй, хамтын ажиллагааны газрын Хуулийн хэлтсийн дарга |
| Б.Хүсэлт | Иргэний нисэхийн үндэсний төвийн Хууль, эрх зүй, хамтын ажиллагааны газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн |
| Б.Өлзийцэцэг | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны эдийн засгийн судалгаа, хөгжүүлэлтийн мэргэжилтэн |
| Н.Лхагвасүрэн | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны программ хангамжийн инженер |
| Б.Буянхүү | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны инновацийн хөгжлийн мэргэжилтэн |
| Э.Батболд | Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны Захиргаа, хүний нөөцийн хэсгийн мэдээлэл технологийн мэргэжилтэн |

------ o0o ------

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн
А/02 дугаар тушаалын тавдугаар хавсралт

**Нэгдсэн дотоод портал бий болгох дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

Ажлын хэсгийн дарга:

| | |
|---|---|
| Ц.Ган-Эрдэнэ | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны менежер |

Гишүүд:

| | |
|---|---|
| Ц.Пүрэвсүрэн | Захиргаа удирдлагын газрын дотоод ажил хариуцсан мэргэжилтэн |
| О.Сэндэр | Дотоод аудитын албаны Хяналт, шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн |
| С.Нямцэрэн | Иргэний нисэхийн үндэсний төвийн Захиргаа хүний нөөцийн газрын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн |
| С.Намуунзул | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны системийн шинжээч-мэргэжилтэн |
| Н.Лхагвасүрэн | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны программ хангамжийн инженер |
| Б.Шижирбат | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны программ хангамжийн инженер |

------ o0o ------

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2021 оны .01.. дүгээр сарын ..18..-ны өдрийн
А/02.... дугаар тушаалын зургаадугаар хавсралт

**Төрийн цахим платформ (eMongolia)-д нэгдэх**
**дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн дарга: | |
| Г.Амарцэцэг | Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны аюулгүй ажиллагаа, дотоод хяналт хариуцсан менежер |
| Гишүүд: | |
| Т.Хадбаяр | Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн хэлтсийн дарга |
| Ч.Дарьсүрэн | Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Нислэгийн стандарт, үйл ажиллагааны хэлтсийн нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч |
| Б.Нямбаяр | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны ахлах мэргэжилтэн |
| С.Нямцэрэн | Иргэний нисэхийн үндэсний төвийн Захиргаа хүний нөөцийн газрын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн |
| Б. Шижирбат | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны программ хангамжийн инженер |
| О.Пүрэвзул | “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын Теле мэдээлэл, холбооны албаны дарга |
| Ц.Жавзанханд | Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны Нисэхийн шуурхай мэдээллийн хэсгийн нисэхийн мэдээллийн мэргэжилтэн |

------ o0o ------

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2021 оны ..01.. дүгээр сарын ..18..-ны өдрийн
A/102.. дугаар тушаалын долоодугаар хавсралт

**Нийтийн үйлчилгээний дата төв байгуулах**
**дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

Ажлын хэсгийн дарга:

| | |
|---|---|
| У.Баярбат | Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, инновацийн албаны мэдээллийн аюулгүй байдлын инженер |

Гишүүд:

| | |
|---|---|
| С.Нямцэрэн | Иргэний нисэхийн үндэсний төвийн Захиргаа хүний нөөцийн газрын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн |
| Б.Буянхүү | Иргэний нисэхийн үндэсний Мэдээллийн технологи, инновацийн албаны инновацийн хөгжлийн мэргэжилтэн |
| О.Пүрэвзул | “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын Теле мэдээлэл, холбооны албаны дарга |
| Э.Булган | Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн дарга |
| Э.Батболд | Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны Захиргаа, хүний нөөцийн хэсгийн мэдээлэл технологийн мэргэжилтэн |
| Г.Энхтүвшин | Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны Тоон мэдээллийн хэсгийн системийн инженер |

------ o0o ------

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2021 оны .01.. дүгээр сарын ..05..-ны өдрийн
А/02 дугаар тушаалын наймдугаар хавсралт

# АЖЛЫН ХЭСГҮҮДИЙН АЖЛЫН УДИРДАМЖ

## НЭГ. ЗОРИЛГО

1.1 Иргэний нисэхийн ерөнхий газрын хэмжээнд тоон гарын үсэгт шилжүүлэн цахимаар мэдээлэл солилцох, өгөгдлийн нэгдсэн дижитал санг бий болгож төрийн цахим сүлжээнд холбох, дижитал шилжилтийн хүрээнд ашиглагдах системийн бэлэн байдал, найдвартай ажиллагааг хангах, мэдээллийн аюулгүй байдлын ISO27001 стандартын дагуу цахим халдлагаас урьдчилан сэргийлэх, хамгаалах системийг хэрэгжүүлэх зорилготой.

## ХОЁР. ҮНДСЭН БА ДЭД АЖЛЫН ХЭСГҮҮД

2.1 Үндсэн ажлын хэсэг нь дэд ажлын хэсгүүдийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаан, төслийн гүйцэтгэл, хэрэгжилтийн явцад хяналт тавьж, үр дүнг тухай бүр тайлагнана.

2.2 Бүртгэлийн ажилтан нь Иргэний нисэхийн ерөнхий газрыг төлөөлөн тоон гарын үсгийн гэрчилгээний баримт бичгийг хүлээн авч, бүртгэлжүүлнэ.

2.3 Дэд ажлын хэсгүүдийн дарга нар хариуцсан ажлын хэсгүүдийн хийгдэх ажлууд, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хангаан, үр дүнг долоо хоног тутамд үндсэн ажлын хэсэгт тайлагнана.

2.3.1 Мэдээллийн системийн нэгдсэн менежмент, аюулгүй байдлын бэлэн байдлыг хангах дэд ажлын хэсэг:

Төслийн хүрээнд мэдээллийн системийн нэгдсэн менежментийг бий болгох, IT сүлжээний бодлогын дүрэм журам гаргах, мэдээллийн системийн аюулгүй байдлын олон улсын түвшний аудит, анализ дүгнэлт хийлгэх, ISO 27001-ийн стандартын дагуу гэрчилгээжүүлэлтийн бэлэн байдлыг хангах, цахим халдлагын аюулгүй байдлыг хангаан, урьдчилан сэргийлэх болон хамгаалах системийг хэрэгжүүлэх юм.

*Хүрэх үр дүн*

Дижитал шилжилтийн стратегийн шаардлагыг хангах мэдээллийн системийн тасралтгүй найдвартай ажиллагааны бэлэн байдлыг хангаж, нэгдсэн мэдээллийн системийн бодлого зохицуулалтын дүрэм журам гарган мөрдүүлэх ба цахим сүлжээний аюулгүй байдлыг бүрэн хангасан байна.

2.3.2 Өгөгдлийн нэгдсэн сан бүрдүүлэх дэд ажлын хэсэг:

Иргэний нисэхийн ерөнхий газар болон түүний харьяа салбар, нэгжүүдийн систем, программ хангамжуудаас мэдээлэл, өгөгдөл, файлуудыг цуглуулах, нөөц үүсгэх, нэгдсэн стандартад хөрвүүлэх, их өгөгдлийн шинжилгээ хийх, анализ судалгааг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах боломжтой нээлттэй дижитал өгөгдлийн нэгдсэн санг бүрдүүлнэ.

*Хүрэх үр дүн*

Салбарын бүхий л нэгдсэн эх сурвалж бүхий дижитал өгөгдлийн санг бий болгох, мэдээллийн анализ хийснээр бизнесийн үйл ажиллагааг сайжруулах, үр ашиг өгөөжийг дээшлүүлэх боломжтой болно.

2.3.3 Тоон гарын үсэг нэвтрүүлэх дэд ажлын хэсэг:

Иргэний нисэхийн ерөнхий газар болон Иргэний нисэхийн үндэсний төвийн хэмжээнд Индекс бүхий ажилтнуудад тоон гарын үсэг эзэмших дахин давтагдашгүй гэрчилгээ бүхий токен төхөөрөмж авах, дотоод болон гадаад албан бичгийн төсөл, албан хэрэг хөтлөлтөнд тоон гарын үсэг зурах программ хангамжийн бэлэн байдал, эрх зүйн боломжыг бүрдүүлэн Үндэсний дата төв болон харьяа байгууллагуудтай холбогдох хамтын ажиллагааны гэрээ хийж, цахим албан хэрэг хөтлөх бэлэн байдлыг хангана.

*Хүрэх үр дүн*

Тоон гарын үсгийн нэвтрэлт, цахим албан хэрэг хөтлөлтийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэнээр цаасгүй оффис болохоос гадна бусад төрийн байгууллагуудын системүүдтэй тоон гарын үсгээр албан бичиг солилцдог болсон байна.

Мөн хол байршилтай байгууллагууд хоорондоо онлайнаар албан бичиг хэргээ солилцох, цаг хугацаа, үйл ажиллагааны зардлыг бүрэн хэмнэх боломжууд бий болно. Тоон гарын үсгийг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхтэй холбоотойгоор Иргэний нисэхийн ерөнхий газрын “Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

2.3.4 Нэгдсэн дотоод портал бий болгох дэд ажлын хэсэг:

Нэгдсэн дотоод портал нь Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа салбар нэгжүүдийн өдөр тутмын процессын гар ажиллагааг автоматжуулан цахимжуулах ба харьяа салбар нэгжүүдийн ажилтанууд өөрийн нууцлал бүхий кодын тусламжтайгаар албан бичиг хэрэг, хүсэлтээ орон зай, цаг хугацаа хамаарахгүйгээр шуурхай солилцох боломжтой юм. Мэдээллийн технологи хурдацтай хөгжиж буй өнөө үед цаасан баримтнаас татгалзаж, цахим хэлбэрт шилжүүлэх нь үйл ажиллагааг хөнгөвчлөхийн дээр, үр бүтээмжийг дээшлүүлнэ.

*Хүрэх үр дүн*

Мэдээллийг нэг системээр дамжуулан авснаар олон харилцагчаас мэдээлэл цуглуулах гэж цаг алдахгүй байхаас гадна хүсэлтээ системээр илгээн батлуулснаар зайнаас хамааралгүйгээр түргэн, шуурхай асуудлыг шийдвэрлэдэг болно. Мөн харьяа салбар нэгжүүдийн уялдаа холбоо сайжирч, мэдээлэл солилцох үйл явц хялбар болох бөгөөд хүний хүчин зүйлээс үүсч болох алдааг багасгана.

2.3.5 Төрийн цахим платформ (e-Mongolia)-д нэгдэх дэд ажлын хэсэг:

Нисэхийн аюулгүй ажиллагааны үнэмлэхжүүлэлт болон гэрчилгээжүүлэлтийн программ хангамжийг хөгжүүлж, Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтад заасан үйлчилгээнүүдийг төрийн нэгдсэн eMongolia цахим порталд нэгдэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

*Хүрэх үр дүн*

Нисэхийн аюулгүй ажиллагааны цахим үнэмлэхжүүлэлтийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байх ба е-Гэрчилгээ системийг шинээр хөгжүүлсэнээр дараах үйлчилгээнүүдийг eMongolia төрийн цахим порталд нэгдсэн байна.

- Аэродромын гэрчилгээ олгох;
- Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгох;

- Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ олгох;
- Нисгэгч, нислэгийн удирдагч, агаарын хөлгийн инженер, нислэгийн мэдээллийн ажилтнуудад үнэмлэх олгох.
- Нислэгийн хуваарь

2.3.6 Нийтийн үйлчилгээний дата төвийн дэд ажлын хэсэг:

Нийтийн үйлчилгээний интернэт, дотоод сүлжээ, серверийн зохион байгуулалтыг сайжруулан, системүүдийн ашиглалтын нөхцөл байдлын шинжилгээ хийх, олон улсын TIA-942 стандартыг хангах шаардлагын дагуу төвлөрсөн дата төвийн тэжээл, хөргөлтийн систем, хяналт мониторингийн бэлэн байдлыг хангах, дижитал шилжилтийн хүрээнд ашиглагдах систем, серверүүдийн сүлжээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор системүүдийг тус дата төв шилжүүлэн байршуулна.

*Хүрэх үр дүн*

Олон улсын TIA-942 стандартын дагуу Tier 2 түвшний дата төвийн тэжээлийн болон хөргөлтийн системүүдийн бэлэн байдлыг хангаан нийтийн үйлчилгээний сүлжээний хатуу дэд бүтэц, серверийн зохион байгуулалтыг сайжруулах, цахим системүүдийн найдвартай ажиллагаанд үүсч болзошгүй эрсдлүүдийг бууруулж, найдвартай ажиллагааг бүрэн хангасан серверийн өрөөнд сэлгэн байршуулна. Шинэ байрны нийтийн үйлчилгээний зориулалтаар ашиглах дата төвийн техникийн шийдэл, зураглалыг гаргана.

--- o0o ---